

## БАНКНЫ ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНГИЙН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Банкны тухай хуулийн 62, 63 дугаар зүйлд заасны дагуу банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийн санг (Цаашид “Сан” гэх) бүрдүүлэх, зарцуулах, удирдах, хянах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журам нь Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль, Банкин дах мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцтэй байна.
- 1.3. Сангийн үйл ажиллагааг Монголбанкны Банкны бодлого, бүтцийн өөрчлөлтийн газар зохион байгуулна.
- 1.4. Сангийн хөрөнгийн удирдлагыг хариуцан хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааны удирдлагын нэгжээс тусдаа байна.

### Хоёр. Сангийн хөрөнгө

#### 2.1. Сангийн хөрөнгө бүрдүүлэлт

- 2.1.1. Сангийн хөрөнгө нь банкнаас төлсөн жилийн хураамж, онцгой хураамж, сангийн хөрөнгө оруулалтын орлогоос бүрдэнэ.
- 2.1.2. Банкнаас төлсөн хураамжийг Монголбанкин дахь сангийн дансанд төвлөрүүлнэ.
- 2.1.3. Банк хураамжийг төлбөл зохих дүнгээс илүү төлсөн тохиолдолд илүү төлсөн хэсгийг Монголбанкин дахь уг банкны харилцах дансанд шилжүүлнэ.

#### 2.2. Жилийн хураамж

- 2.2.1. Монголбанкнаас системийн ач холбогдолтой гэж тооцсон банк нь жилийн хураамжийг Монголбанкин дахь сангийн дансанд жил бүр төлнө.
- 2.2.2. Жилийн хураамжийг тооцох **суурь** нь банкны өмнөх оны жилийн эцсийн нийт өр төлбөрийн дүн байна.
- 2.2.3. Жилийн хураамж нь **үндсэн** болон **эрсдэлийн нэмэлт хувь** гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.
- 2.2.4. **Үндсэн болон эрсдэлийн нэмэлт хувийг** энэхүү Монголбанкнаас **жил бүрийн аравдугаар сарын 31-ний** өдрийн дотор Банкы хяналт шалгалтын хороогоор хэлэлцэж Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.

- 2.2.5. Банк нь жилийн хураамжийг Монголбанкнаас банкуудад хүргүүлсэн жилийн хураамжийн нэхэмжлэлд заасан хугацаанд төлнө.
- 2.2.6. Банкнаас бүрдүүлсэн жилийн хураамжийн нийт үлдэгдэл банкны системийн нийт хадгаламжийн 1 хувьд хүрсэн тохиолдолд жилийн хураамж хуримтлуулахыг түр зогсоож болно.
- 2.2.7. Банкны хураамж төлөх үүрэг нь Банкны тухай хуулийн дагуу банкиг татан буулгах буюу банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гарснаар дуусгавар болно.

### **2.3. Онцгой хураамж**

- 2.3.1. Сангийн хөрөнгө нь банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй тохиолдолд банкуудаас төлөх нийт онцгой хураамжийн дүнг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.
- 2.3.2. Онцгой хураамж авах шийдвэр гаргахдаа бүтцийн өөрчлөлтөд шаардлагатай санхүүжилтийн тооцоо, судалгааг Монголбанкны Хяналт, шалгалтын хорооны хурлаар хэлэлцүүлэн, бүтцийн өөрчлөлтийн бусад боломжит санхүүжилтийн эх үүсвэрүүдийг бүрэн ашигласны дараах дутагдлын хэмжээнд үндэслэн онцгой хураамжийн хувийг тогтооно.
- 2.3.3. Онцгой хураамжийн хувийг Банкны тухай хуулийн 63.3-т заасны дагуу системийн хадгаламжийн 0.3 хувиас хэтрүүлэхгүйгээр тогтооно.
- 2.3.4. Онцгой хураамжийн суурийг энэ журмын 2.2.2-д тодорхойлсон жилийн хураамжийн суурьтай ижил сууриар, хураамжийн хувийг энэ журмын 2.2.4-д тодорхойлсон хувиар тооцно.
- 2.3.5. Монголбанкнаас онцгой хураамжийн нэхэмжлэлийг банканд хүргүүлснээс хойш 30 хоногийн дотор банк хураамжийг төлнө.
- 2.3.6. Банкнаас төлөх онцгой хураамж нь "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын 3.4-т заасан хөрвөх чадвартай хөрөнгө байна.
- 2.3.7. Онцгой хураамж төлүүлэх шийдвэр гаргахаас өмнө онцгой хураамж төлснөөр банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтэд үзүүлэх нөлөөллийн судалгааг банк тус бүрээр гаргаж Банкны хяналт шалгалтын хороонхуралд танилцуулна.
- 2.3.8. Онцгой хураамж төлснөөр аливаа банк Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангахгүй гэсэн Банкны хяналт шалгалтын хорооны зөвлөмж гарсан тохиолдолд тухайн банкны онцгой төлбөрийн хураамж төлөх хугацааг 1 жил хүртэлх хугацаагаар хойшлуулж болно.

### **Гурав. Сангийн зарцуулалт**

### **3.1. Сангийн зарцуулалтын зориулалт, шийдвэр гаргалт**

- 3.1.1. Сангийн хөрөнгийг зөвхөн банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийг санхүүжүүлэх болон санг удирдахтай холбоотой гарах зардалд зарцуулна.
- 3.1.2. Банкны тухай хуулийн 54.1-т заасан үндэслэл бүрдэж, Монголбанкнаас банканд бүтцийн өөрчлөлт хийх шийдвэр гарсан тохиолдолд Банкны тухай хуулийн 61.1-д заасны дагуу Сангаас дараах хэлбэрийн зарцуулалт хийгдэж болно:
  - 3.1.2.1. Бүтцийн өөрчлөлт хийгдэж буй банкны актив, пассивт баталгаа гаргах;
  - 3.1.2.2. Бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээнд оролцож буй банкинд зээл олгох;
  - 3.1.2.3. Бүтцийн өөрчлөлт хийгдэж буй банкны хөрөнгийг худалдан авах;
  - 3.1.2.4. Тусгай зориулалтын банкинд хөрөнгө оруулах;
  - 3.1.2.5. Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн дутагдал, зөрүүг нөхөх;
- 3.1.3. Энэ журмын 3.1.2.-т заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх тохиолдолд дээрх арга хэмжээнүүдэд шаардлагатай сангийн зарцуулалтын хэмжээг нарийвчлан тодорхойлж, Банкны хяналт шалгалтын хорооны хурлаар шийдвэрлүүлнэ.
- 3.1.4. Монголбанкнаас томилогдсон Банкны тусгай төлөөлөгч нь Сангаас үзүүлэх дэмжлэгийн хэлбэр болон зарцуулалтын талаарх шаардлагатай мэдээллээр Сангийн удирдлага хариуцагч нэгжийг хангана.
- 3.1.5. Сангийн хөрөнгийг банкны хүлээсэн алдагдлыг нөхөх, банкны дахин хөрөнгөжүүлэх, банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд зарцуулахыг хориглоно.
- 3.1.6. Сангаас олгох санхүүжилт нь хөрвөх чадвартай хөрөнгө байна.

### **4. Дөрөв. Сангийн хөрөнгө оруулалт**

- 4.1. Сангийн Хөрөнгө оруулалтын бодлогыг Банкны хяналт шалгалтын хорооны хурлаар хэлэлцүүлж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.
- 4.2. Сангийн хөрөнгө оруулалтын бодлого анхлан батлагдан гарахаас өмнө сангийн нийт хөрөнгийг Монголбанкн дахь Сангийн дансанд байршуулна.
- 4.3. Сангийн хөрөнгийг Банкны тухай хууль болон энэ журамд нийцүүлэн гаргасан Хөрөнгө оруулалтын бодлогод нийцүүлэн удирдана.

- 4.4. Сангийн хөрөнгийг аюулгүй, хөрвөх чадвартай байх зарчмыг баримтлан дараах түргэн борлогдох активуудад байршуулж болно:
  - 4.4.1. Монгол улсын Засгийн газраас гаргасан үнэт цаас;
  - 4.4.2. Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд болох Standard&Poors, Fitch, Moody's байгууллагаас тогтоосон AAA, (Aaa), (prime)-ээс доошгүй үнэлэгдсэн гадаад улсын засгийн газрын болон олон улсын санхүүгийн байгууллагын үнэт цаас;
  - 4.4.3. Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банкинд нээсэн хадгаламж;
- 4.5. Сангийн хөрөнгийн удирдлага хариуцагч нь хөрөнгө оруулалтын саналыгулирал бүр холбогдох мэдээллийн хамт Банкны хяналт шалгалтын хорооны хурлаар хэлэлцүүлж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлуулна.
- 4.6. Сангийн хөрөнгө оруулалтын санал нь дараах мэдээллийг агуулсан байна:
  - 4.6.1. Сангаас оруулалт хийх боломжтой үлдэгдлийн мэдээ;
  - 4.6.2. Хөрөнгө оруулалтын багц (жигнэсэн дундаж өгөөж болон хугацаа);
  - 4.6.3. Бусад шаардлагатай мэдээлэл, санал.
- 4.7. Сангийн хөрөнгийн удирдлага хариуцагч нь сангийн хөрөнгийг энэ журмын 4.4-д заасан шаардлагад нийцсэн хөрөнгөд энэ журмын 4.6-д заасан хөрөнгө оруулалтын саналын дагуу байршуулна.
- 4.8. Сангийн хөрөнгийн удирдлага хариуцагч нь хөрөнгө оруулалтын ирэх жилийн төлөвлөгөөг тухайн оны 3 дугаар улиралд багтаан боловсруулж, 4 дүгээр улиралд багтаан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлуулна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд дараах мэдээллийг тусгана:
  - 4.8.1. Хөрөнгө оруулалт хийх боломжтой хөрөнгийн хэмжээ;
  - 4.8.2. Хөрөнгө оруулалтын багцын ерөнхий төлөвлөгөө;
  - 4.8.3. Хөрөнгө оруулалтын багцын актив тус бүрийн өгөөж;
  - 4.8.4. Хөрөнгө оруулалтын өгөөжөөс олох орлогын төсөөлөл;
- 4.9. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жил бүр бэлтгэн Банкны хяналт шалгалтын хороонд танилцуулна.
- 4.10. Банкны тухай хуулийн 62.3-т заасны дагуу Сангийн хөрөнгийн удирдлагыг дотоод болон гадаадын үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй, хөрөнгийн удирдлагын туршлагатай, санхүүгийн чадавхтай, найдвартай, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

- 4.11. Сангийн хөрөнгийг энэ журмын 4.10-д заасан мэргэжлийн хуулийн этгээдээр удирдуулсан тохиолдолд холбогдох зардлыг сангийн хөрөнгөөс гаргана.

#### **5. Тав. Сангийн үйл ажиллагааны санхүүгийн тайлагнал**

- 5.1. Сангийн санхүүгийн тайлан болон бусад үйл ажиллагааны тайланг Монголбанкны тайлангаас тусад нь бэлтгэнэ.
- 5.2. Сангийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн бэлтгэнэ.
- 5.3. Сангийн санхүүгийн тайланд хараат бус аудитыг жилд нэг удаа хийлгэнэ.
- 5.4. Сангийн нийт хураамжийн үлдэгдэл, сангийн хөрөнгө оруулалттай холбоотой орлого, зардлын талаарх мэдээллийг Монголбанк банкуудад болон олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

#### **6. Зургаа. Банкуудтай харилцах харилцаа**

- 6.1. Жилийн хураамжийн хувь тогтоосон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор уг тушаалын хуулбарыг, жилийн хураамжийн нэхэмжлэлийн хамт банкинд албан бичгээр хүргүүлнэ.
- 6.2. Монголбанк жилийн хураамжийг хуримтлуулахыг түр зогсоосон үед үргэлжлүүлэн хуримтлуулах шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор банкуудад албан бичгээр мэдэгдэнэ.
- 6.3. Монголбанкнаас онцгой хураамж төвлөрүүлэх тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал гарснаас ажлын 5 хоногийн дотор банкуудад мэдэгдэж, нэхэмжлэлийг хүргүүлнэ.
- 6.4. Монголбанк нь банкны төлөх хураамжийн суурь болон хувь бодох тооцоолол, бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай тайлан мэдээг банкуудаас шаардан авах эрхтэй.

#### **7. Долоо. Хяналт, хариуцлага**

- 7.1. Банк хураамжийг тогтоосон хугацаанд бүрэн төлөөгүй, хэсэгчлэн төлөөгүй, төлөлт хийгдсэн боловч Монголбанкнаас тогтоосон төлбөрийн нөхцөлийн шаардлага хангаагүй тохиолдолд холбогдох нөхөн төлбөрийг Монголбанкин дахь тухайн банкны харилцах данснаас суутган авна.
- 7.2. Жилийн болон онцгой хураамжийг тогтоосон хугацаанд төлөөгүй банкны төлөөгүй дүнд Монголбанкны бодлогын хүүтэй тэнцэх хувиар тооцож алданги ногдуулна. Алдангийг тухайн банкны Монголбанкин дах харилцах данснаас суутган авна.
- 7.3. Хураамжийг заасан хугацаанд төлөөгүй, алданги ногдуулсан банкны мэдээллийг Монголбанкны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлнэ.

- 7.4. Сангийн үйл ажиллагаа хариуцсан Монголбанкны нэгж нь энэ журмын 7.1-д заасан хураамжийг суутгуулах тухай хүсэлтийг хураамжийн төлөх хугацаа, сунгасан хугацаа дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор газар хоорондын албан бичгээр, тооцооллын хамт Монголбанкны Төлбөр, тооцооны газар хүргүүлж шийдвэрлүүлнэ.
- 7.5. Сангийн хөрөнгө оруулалт хариуцсан нэгж нь хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг Монголбанкны удирдлагад улирал бүр танилцуулна.
- 7.6. Сангийн үйл ажиллагаанд Монголбанкны Дотоод аудитын газар жил бүр шалгалт хийж тайлангаа Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулна.
- 7.7. Сангийн үйл ажиллагаанд энэ журмын 5.3-д заасны дагуу хийгдсэн хөндлөнгийн байгууллагаар хийгдсэн аудитын тайланг дүгнэлтийн хамт олон нийтэд Монголбанкны цахим хуудсаар дамжуулан нээлттэй мэдээлнэ.
- 7.8. Энэ журмын хэрэгжилтэд Монголбанкны Дотоод аудитын газар тогтмол хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.
- 7.9. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----- оОо -----